1.1. ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлтүүд		Тодорхойлолтууд
Ерөнхий танилцуулга		
Аж ахуйн нэгжийн нэр		Заамар өгөөмөр хайрхан ХХК
Уурхайн нэр		Баян-Овоот уул талбайн дэнжийн хэсэг
Ордын нэр ба тусгай зөвшөөрлийн дугаар		Баян-Овоот уул талбайн дэнжийн хэсэг алтны шороон орд MV-005092
Уул техникийн нөхцөлийн талаар		
Ордын батлагдсан нөөц		$B+C=11.2$ кг /химийн цэвэр/
Ил уурхайн хүрээн дэх үйлдвэрлэлийн нөөц		$B'=9.32$ кг /химийн цэвэр/
Элсний давхаргын зузаан		1.1 м
Хучаас хөрсний зузаан		14.15 м
Ашиглах арга ба хугацаа		Ил аргаар 1 жил
Ашиглалтын систем		Дотоод овоолготой, авто тээвэртэй
Шимт хөрс хуулалт		4.95 мян.м3
Хөрс хуулалт		474.07 мян.м3
Элс олборлолт		33.68 мян.м3
Уурхайн өндөржилт (далайн түвшнээс дээш)		935 м
Доголын өндөр	Хөрс	5 м
	Элс	1.1 м
Доголын налуугийн өнцөг		45-55

**“БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, НӨХӨН
СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Алтны металл авалт		91.80%
Бүтээгдэхүүн гаргалт	Баяжмал дахь алт (шлихээр)	9.55 кг
	Баяжмал дахь алт (хими цэвэр)	8.56 кг
Уурхайн үндсэн техник тоног төхөөрөмжүүд		3.5м3-ийн утгуурын багтаамжтай CAT349 маркийн урвуу утгуурт экскаватор
		2 м3-ийн утгуурын багтаамжтай CAT329 маркийн урвуу утгуурт экскаватор
		90 кВт-ийн хүчин чадалтай SHANTUI фирмийн SD13 маркийн бульдозерууд
		50, 20 тн даацтай HOWO маркийн автосамосвалууд
		3.5 м3 -н шанаганы багтаамжтай Komatsu WA430 маркийн утгуурт ачигч
Баяжуулалтын үндсэн тоног төхөөрөмжүүд		Геомаш-40 угаах төхөөрөмж
		6s-7.6 маркийн баяжуулах ширээ
		Эргэлтийн усны насосууд
Цахилгаан хангамж		Төвийн эрчим хүчний нэгдсэн систем

1.2. УУРХАЙН ХААЛТЫН БОДЛОГО

Олборлолтын практик ажиллагааг үндэслэн аюулгүй, тогтвортой газрын гадарга үлдээх нь гол зорилго юм. Уурхайн хаалтын ажлын үед дараах ажлуудыг хийнэ. Үүнд:


- ❖ Уурхайн зориулалтаар баригдсан цахилгаан шугамыг цаашид ашиглах боломжийг судлаж, орон нутагтай зөвшилцөн шаардлагатай газар шилжүүлэн татаж орхино.
- ❖ Нөхөн сэргээсэн газар талбайг орон нутгийн засаг захиргаанд хүлээлгэн өгч нөхөн сэргээгдсэн талбайг энгийн зориулалтаар ашиглаж болохуйц хүртэл нэмэлт арчилгаа хийх, хяналт гаргах.
- ❖ Уурхайн хаалтын тухай орон нутгийн засаг захиргаатай гэрээ байгуулан хамтран ажиллах, тодорхой хариуцсан ажилтныг томилох, цалинжуулах ажилд уурхай хөрөнгө гаргах.
- ❖ Шаардлагатай газруудад тэмдэг тэмдэглээ хийх, анхааруулах болон мэдээлэх самбар хийх

Дээрх ажлуудыг уурхайн талаас хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд орон нутгийн удирдлагын санал санаачлагын дагуу уурхайн хаалтын дараах эдэлбэр газрыг Бэлчээрийн зориулалтаар цаашид ашиглахыг харилцан ярилцаж тодорхойлох нь үр дүнтэй.

“БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.3. Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн дараах шалгуурыг хангана.

Баян-Овоот уул талбайн дэнжийн хэсэг буюу Баянголын дэнжийн дээд хэсгийн (ХШ 722а-723) алтны шороон ордын хаалтын төлөвлөгөө, , нөхөн сэргээлтийн төлөвлөгөө дараах шалгуурыг ханган ажиллахаар төлөвлөж байна.



1.4. Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх дараалал

Баянголын дэнжийн алтны шороон ордын хаалт, нөхөн сэргээлтийн ажлыг дараах дарааллын дагуу зохион байгуулхаар төлөвлөж байна.



Зураг 3. Ажилчдын хотхон орчмын төлөв байдал

ХОЁР. УУРХАЙН ХААЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТЭД АШИГЛАГДАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Тус ордын хөрс хуулалт, элс олборлолтын уулын ажилд хэрэглэгдэх үндсэн техник, тоног төхөөрөмжүүдийг түрээсээр ашиглах ба храалтын үйл ажиллаанд бас ашиглагдана.

Уурхайд дараах нэр төрлийн техникууд ажиллана. Үүнд:

- ❖ 3.5 м3-ийн утгуурын багтаамжтай CAT349E маркийн урвуу утгуурт экскаватор
- ❖ 90 кВт-ийн хүчин чадалтай SHANTUI фирмийн SD13 маркийн бульдозерууд
- ❖ 50, 20 тн даацтай HOWO маркийн автосамосвалууд
- ❖ 3.5 м3 -н шанаганы багтаамжтай Komatsu WA430 маркийн утгуурт ачигч
- ❖ Туслах машин механизм (үйлчилгээний машинууд г.м.)

Хүснэгт 3. CAT 349E L маркийн экскаваторын үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоон үзүүлэлт
1	Утгуурын багтаамж	м3	3.5
2	Сумны урт	м	6.9
3	Гарын урт	м	12.1
4	Утгалтын түвшин дэх утгах радиус	м	10.7
	Утгалтын хамгийн их радиус	м	12.9
6	Утгалтын их гүн	м	8.1
7	Утгалтын хамгийн их өндөр	м	11.1
8	Утгалтын их өндөр	м	11.1
9	Их биеийн өргөн	мм	3490
10	Их биеийн өндөр	мм	3390
11	Эргэх тавцан хүртэлх өндөр	мм	1280
13	Явах ангийн урт	мм	5370
14	Явах ангийн өргөн	мм	3490
15	Гинжний өргөн	мм	600
16	Хөдөлгүүрийн чадал	кВт	295
17	Мөчлөгийн хугацаа	сек	28



Зураг 4. CAT 349E L маркийн экскаватор

**“БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, НӨХӨН
СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 4. SD-16 бульдозерын үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Нэгж	Тоо хэмжээ
1	Хөдөлгүүрийн чадал	кВт/м.х/	120/1850/
2	Хутганы өргөн	мм	4150
3	Хутганы өндөр	мм	960
4	Түрэх призмийн эзлэхүүн	м3	3.8
5	Овор хэмжээ	Урт	5262
		Өндөр	4150
		Өргөн	3074
6	Шигтгэх гүн	мм	485
7	Жин	тн	17.5
8	Өгсөх налуу	град	30
9	Хурд	км/цаг	3.29-9.63
10	Түлш зарцуулалт	л/цаг	25



Зураг 5. SD-16 бульдозер

Хүснэгт 5. Sinotruk HOWO маркийн автосамосвалын үзүүлэлт

№	Үзүүлэлт	Тоон утга
1	Хөдөлгүүрийн загвар	ISTEYR
2	Хөдөлгүүрийн чадал, кВт	279, 2000 эрг/мин
3	Түлшний савны багтаамж, л	380
4	Дугуй	14.00-20, 14.00R20
5	Өөрийн жин, кг	22090
6	Ачаалал хуваарилалт, кг	20000
	Урд тэнхлэгт	30000
	Хойд тэнхлэгт	
7	Даац, кг	50000
8	Оврын хэмжээ, мм (урт, өргөн, өндөр)	10235x2496x3150
9	Тэвшний геометр багтаамж, м3	31.2
10	Дээд хурд, км/цаг	75
11	Түлш зарцуулалт, л/100км	42
12	Эргэх хамгийн бага радиус, м	10

**“БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, НӨХӨН
СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



*Зураг 6. Sinotruk HOWO маркийн автосамосвал
Хүснэгт 6. Dongfeng 6*4 усалгааны машинын үзүүлэлт*

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Dongfeng 6*4
1	Дугуйн томьёо		6x4
2	Хөдөлгүүрийн чадал	м.х/кВт	210/155
3	Усны савны багтаамж	л	18-20
4	Ус цацах бүс (өргөн* урт)	м	16*28
5	Хөдөлгүүрийн чадал	м.х/кВт	450/335
6	Хамгийн их хурд	км/цаг	85
7	Өгсөх налуу	град	10
8	Жин	тн	5.2
9	Түлшний савны багтаамж	литр	200
10	Оврын хэмжээ (Урт*өргөн*өндөр)	мм	9950*2490*3350



*Зураг 7. Dongfeng 6*4 усалгааны машин*

ГУРАВ. ТӨСЛИЙН ТАЛБАЙГ ЦЭВЭРЛЭХ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУДЫГ БУУЛГАХ

3.1. ТАТАН БУУЛГАЛТ

Дараах дарааллын дагуу нүүлгэн шилжүүлэх татан буулгах ажлыг зохион байгуулна.



3.2. ХАЯГДЛЫН САН СААРМАГЖУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хаягдлын сангийн байгууламж нь далан, хаалт, хаягдлын сан, булинга дамжуулах хоолой, насосын станц зэргээс бүрдэнэ. Элс угаан баяжуулах цехийн хаягдлын сан доорх нөхцөл шаардлагыг хангасан байна. Үүнд:


- ❖ Ашиглалтын үед болон хаалтын дараа тогтвортой байдлаа хадгалах
- ❖ Хаягдал усыг эргүүлж ашиглах боломж бүрдсэн байх
- ❖ Үерийн болзошгүй аюулаас хамгаалагдсан байх
- ❖ Хаягдал тээвэрлэх зардал хямд байх
- ❖ Хаягдал тээвэрлэхтэй холбоотой хүрээлэн буй орчны сөрөг нөлөөлөл хамгийн бага байх зэрэг болно.

Баяжуулах цехийн хаягдал нь 20 мм-ээс дээш ширхэглэлтэй галь, 20 мм-ээс доош ширхэглэлтэй эфель байна. Эдгээр хаягдлуудыг нийлүүлж олборлолт явуулсан ил уурхайн орон зайг дүүргэх замаар техникийн нөхөн сэргээлтэд ашиглана. Эфелээс ялгарсан усыг урьдчилан бэлтгэсэн нуурын тусламжтайгаар тунгааж цэвэршүүлээд эргэлтийн усаар ашиглана. Элс угаалтыг гравитацийн аргаар явуулах тул хаягдал нь химийн хортой материал агуулахгүй. Гадаргад ил гарсны дараа гадаргын усны нөлөөгөөр рН-ийн тэнцвэр нь алдагдахгүй тул гадаргын болон гүний усны шинж чанарт сөргөөр нөлөөлөхгүй.

Хаягдлын санд хаягдах булинга өөрийн жингээр тунах ба ялгарсан усыг эргэлтийн усан сан руу насосоор шахаж, эргэлтийн усан сангаас угаах төхөөрөмж эсрэг талаас эргэлтийн усны шахуургуудыг байрлуулан угаах төхөөрөмжүүдийг усаар ханган ажиллана.

Булинга хуримтлуулах сангийн урт, өргөний хэмжээ 150х150 м, гүн нь 2-3 м байна. Баяжуулах үйлдвэрийн хаягдал нь төслийн нийт хугацаанд боловсруулалтаас хаягдаж буй 8.92 мян.м3 галь, 24.76 мян.м3 эфель байна.

**“БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, НӨХӨН
СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 8. Хаягдлын далангийн дэвсгэр зураг

Хаягдлын далан нь тус бүр урт, өргөний хэмжээ 150х150 м, гүн нь 2-3 м байна. Баяжуулах үйлдвэрийн хаягдал нь төслийн нийт хугацаанд боловсруулалтаас хаягдаж буй 8.92 мян.м3 галь, 24.76 мян.м3 эфель байна.

Дараах дарааллын дагуу хаягдлын сан саармагжуулах ажлыг зохион байгуулна.

Төлөвлөлт:

- ❖ Хаягдлын далан
- ❖ Нуруулдан уусгах талбай
- ❖ Хаягдлын сан имийн бодисын
- ❖ Баяжуулах үйлдвэр
- ❖ Усан сан, шугам хоолой

Гүйцэтгэл:

- ❖ Хаягдлын далангийн тогтворжилт, аюулгүй байдал
- ❖ Далан дахь үлдэгдэл усыг уусгах шавхах
- ❖ Даланг Зайлах, цэвэрлэх
- ❖ Барилга, тоног төхөрөмжийг хоослох, цэвэрлэх,

Татан буулгалт:

- ❖ Хаших, хамгаалах
- ❖ Буулгах, зөөх
- ❖ Хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах
- ❖ Далангийн усыг шавхах

Хяналт:

- ❖ Хаягдлын далангийн тогтворжилтийн хяналт
- ❖ Гадаргын болон газрын доорх усны чанарын хяналт хийх
- ❖ Хаалтын дараах Байгаль орчны мониторинг хийх

ДӨРӨВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ашиглалтын жилийн хугацаанд уурхайлалт **4.1га** талбай өртөх ба нийт эвдрэлд **17.8га** өртхөөр байна. Нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэх шаардлагатай.

Д/д	Эвдрэлд өртөх талбай	Талбайн хэмжээ
1.	Хөрсний дотоод овоолго	2.9 га
2.	Өмнөх онуудын ухашыг дүүргэсэн дотоод овоолго	1.9 га
3.	Шимт хөрсний овоолго	0.5 га
4.	Баяжуулах үйлдвэр	3.2 га
5.	Хаягдлын овоолго	0.8 га
6.	Уурхайн тосгон	2.2 га
7.	Засварын цех	0.5 га
8.	ШТС	0.005 га
9.	Зат, зогсоол	1.7 га
10.	Уурхай	4.1 га
Нийт эвдрэлд өртөх талбайн хэмжээ		17.8



Тус уурхайн нийт хугацаанд үүсэх ухаш нүхнүүдийн хувьд налуулж тэгшлэн нуур үүсгэх мэтээр үлдээж, овоолго болон талхлагдсан газруудад техникийн нөхөн сэргээлтийн ажлын ухаж ачих, тээвэрлэх ажил шаардлагагүй, хэлбэржүүлэх, тэгшилэх, үржил шимт хөрсөөр хучих, нягтруулах ажлыг гүйцэтгэнэ.


Уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн талбайг хөдөө аж ахуйн техник хэрэгсэл болон мал амьтан чөлөөтэй зорчих хүртэл налуулан тэгшилж техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийнэ.

Уурхайн ашиглалтын нийт хугацаанд 4.95 мян.м³ үржил шимт хөрс, 474.07 мян.м³ үндсэн хөрс хуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ. Өмнөх онуудын ашиглалтаар үүссэн хоосон орон зайд сийрэгжилт тооцсоноор 111.4 мян.м³ хөрс, энэ оны ашиглалтаар үүсэх хоосон орон зайд сийрэгжилт тооцсоноор 446.58 мян.м³ хөрс буцааж хийж дотоод овоолго үүсгэнэ.

Хүснэгт 7. Овоолгын үндсэн үзүүлэлтүүд /сийрэгжилт тооцсон/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Талбай, га
1	Хөрсний дотоод овоолго	мян.м ³	446.58	2.9
2	Өмнөх онуудын ухашыг дүүргэсэн дотоод овоолго	мян.м ³	111.4	1.9
3	Шимт хөрсний овоолго	мян.м ³	5.94	0.5

**“БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, НӨХӨН
СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 9. Нөхөн сэргээлтийн дэвсгэр зураг

4.1. ТАЛБАЙГ НӨХӨН СЭРГЭЭХ АРГАЧЛАЛ

Эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх үндсэн зорилго нь ашиглагдаж дууссан нөөцийг нөхөн үйлдвэрлэлийн аргаар аж ахуйн эргэлтэнд дахин оруулах явдал юм. Эвдэрсэн уг талбайг нөхөн сэргээх ажлыг техникийн болон биологийн нөхөн сэргээлт гэсэн 2 үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.

Техникийн нөхөн сэргээлтийн үе шат

- ❖ Ухмалыг овоолгоор дүүргэх
- ❖ Нөхөн сэргээсэн газрын цаашдын ашиглалтад нийцүүлэн гадаргууг засч янзлах.
- ❖ Үржил шимт болон шимэрхэг хөрсөөр хучих

Биологийн нөхөн сэргээлтийн үе шат

- ❖ Тарих ургамлыг сонгох
- ❖ Газрыг ашиглах дараагийн чиглэлд нийцүүлэн ургамалжуулах
- ❖ Арчлалт, тордолгоо

Нөхөн сэргээгдсэн газрын мониторинг, хамгаалалт

- ❖ Нөхөн сэргээсэн газрын хөрс элэгдэл, эвдрэлд орохоос хамгаалах.
- ❖ Хөрсний үржил шим, шинж чанарыг хянах.
- ❖ Хөрсний элэгдэл, эвдрэлийг хянах.
- ❖ Хөрсөн дэх бохирдуулагч бодисыг хянах.
- ❖ ГЗМС, тандан судалгааны аргаар хянах
- ❖ Нөхөн сэргээлтийн хянан магадлал зэрэг ажлуудыг нөхөн сэргээлтийн үед хийнэ.
- ❖ Нөхөн сэргээлтийн дээрх үе шатыг хийж гүйцэтгэх үндсэн аргачлалыг дор дурьдав.


4.2. ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ

Техникийн нөхөн сэргээлт гэдэг нь эвдэрсэн газрыг тэгшлэх хэлбэржүүлэх анхан шатны үйл ажиллагаа бөгөөд биологийн нөхөн сэргээлт хийх үндэс суурь нь болдог. Төслийн эвдэрсэн газрыг хөдөө аж ахуйн чиглэлээр буюу бэлчээрийн зориулалттай ашиглахаар нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.

“БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн үндсэн болон туслах тоног төхөөрөмжүүдийг ашиглан хийж гүйцэтгэнэ. Техникийн нөхөн сэргээлтийн ажилд доорх ажлууд хамаарна. Үүнд:

- ❖ Ил уурхай, гадаад овоолго болон бусад талбайн шимт хөрсийг бульдозероор хуулах ажил
- ❖ Ил уурхай, гадаад овоолго болон бусад талбайн шимт хөрсийг ачих
- ❖ Шимт хөрсийг тээвэрлэх, овоолгод тусгайлан хураах ажил
- ❖ Хөрсний гадаад болон дотоод овоолгыг хэвгийжүүлэх
- ❖ Ил уурхайн хажууг хэвгийжүүлэх
- ❖ Тусгайлан хураасан үржил шимт хөрс болон орчин үеийн хурдсыг ачих ажил
- ❖ Тусгайлан хураасан үржил шимт хөрс болон орчин үеийн хурдсыг тээвэрлэх ажил
- ❖ Тусгайлан хураасан үржил шимт хөрс болон орчин үеийн хурдсыг тараах ажил




Зураг 10. Ил уурхайн ашиглалтын дараах эцсийн байдлын дэвсгэр зураг

4.3. Биологийн нөхөн сэргээлт

Биологийн нөхөн сэргээлтэнд техникийн нөхөн сэргээлт хийсэн газарт хөрсний үржил шимийг сэргээх, ургамалжуулах зорилготой хийгдэх агротехник, фитомелиорацийн зэрэг ажил багтана.

Биологийн нөхөн сэргээлтийн гол зорилго нь техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг үржил шимт хөрсөөр 0.2- 0.3 м зузаантайгаар хучиж ургамалжуулахад оршино. Ингэснээр сөрөг нөлөөлөлд өртсөн газрын хөрс шороо салхинд хийсч агаар орчныг бохирдуулахаас хамгаалахаас гадна түүнийг байгалийн унаган төрхөд нь ойртуулах, малын бэлчээр, хөдөө аж ахуй болон бусад зориулалтаар ашиглах боломжийг бүрдүүлнэ.



Зураг 11. Овоолгод биологийн нөхөн сэргээлт хийх ерөнхий схем

Талбайг ургамалжуулахдаа нутгийн унаган ургамлын төрөл зүйлийг илүүтэй авч үзэх хэрэгтэй. Иймд нөхөн сэргээлтэнд төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн 50 км хүртэл радиус доторх ямар нэг нөлөөлөлд өртөөгүй ургамлан нөмрөгийг төрөл зүйлээс сонгож авч болно.

4.4. ТАРИХ УРГАМЛЫГ СОНГОХ

Эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд ашиглах нэлээд үр дүнтэй үндсэн ургамлууд нь бэлчээрийн олон наст ургамлууд ордог. Олон наст үндэслэг үетэнгүүдийн үндэс хөгжил сайтай, орчиндоо сайн зохицон ургадаг чанараараа бусад ургамлаас ялгаатай ба газрын гадаргыг үндэсжүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг.

Буурцагт ургамлууд хөрсийг азотоор баяжуулж, эвдэрсэн газрын хөрсний үржил шимийг нэмэгдүүлдэг онцлогтой тул нөхөн сэргээлтэд өргөн сонгоно.

Биологийн нөхөн сэргээлтийн нөмрөг ургамалд овъёос, арвай, зэрэг ургах эрчим сайтай нэг наст ургамлыг сонгон тариалах нь зүйтэй. Нөмрөг ургамал нь үрээр ургах, биомасс хуримтлуулах чадвар сайтай тул нөхөн сэргээлтийн үндсэн буюу олон наст ургамлыг нөхөн сэргээлтийн талбайд байршин ургах эхний жилд хөрсний чийг, дулааны горимыг тэнцвэржүүлж, нарнаас сүүдэрлэж өгдөг учир хамгаалалтын чухал үүргийг гүйцэтгэдэг.

Нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны идэвхтэй хугацаа жилийн 4 улирлын горимтой манай орны нөхцөлд ургамал идэвхтэй ургах вегетацийн хугацаатай тохирч байх шаардлагатай. Энэ хугацаанд байгаль газарзүйн өөр бүс нутгуудад харилцан өөр өөр байдаг. Биологийн нөхөн сэргээлтийн технологийн үндэслэл нь байгаль, газарзүйн бүс бүслүүр, түүний экосистемийн ялгавартай төлөвшил байна. Тиймээс ялгавартай орон зайд технологийн ялгавартай сонголтууд байх шаардлагатай болно.

Үрийн норм: Өвслөг ургамлыг тариалахад 0.01 га-д дунджаар 10-20 грамм үр орохоор тооцоолно. Үрийн соёолох чадвар болон үрийн цэвэршилтээс хамааран 0.01 га талбайд 5,000 - 10,000 ургамал амьдарч ургахаар тооцоолж үр тариалах нормыг тогтооно. Үет болон буурцагт ургамлын хольцыг аль ч тохиолдолд адил тэнцүү хэмжээтэй авах нь зүйтэй.

Тарих арга: Нөхөн сэргээлтийн талбайн хөрсний үржил шимийг нэмэгдүүлэхэд бордоо хэрэглэвэл үр дүн сайтай болно. Үржил шимт хөрсний нимгэн давхаргатай хээрийн болон говийн бүсэд орон нутгийн олдоц арвинтай бууц, органик гаралтай бусад зүйлс (модны үртэс, нийтийн хоолны хаягдал, биоялзмаг г.м)-ийг 1.0 га-д 30-аас багагүй тн-оор тооцон хэрэглэнэ. Мод, сөөгийг эгнээ хоорондын зай нь 5м, мод хоорондын зай нь 4м байхаар тооцож 1 га-д 500 ширхэг байхаар тооцож тарина.

Олон наст ургамлын үр ус чийгийг их шаарддаг тул үрийг орон нутгийн зонхилох

“БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

салхины хөндлөн чиглэлд 2-3 см гүнд суулгаж ус чийгийг алдагдуулахгүйн тулд шууд булдах хэрэгтэй. Техникийн болон биологийн үе шатны хооронд 2-3 жил хөрс сайжруулалт хийх хэрэгтэй. Эхний жил буурцагт ургамлуудыг ижил хэмжээтэй хольж тарина. Азотын бордоог 200 кг/га орцтойгоор хийж болно. Нөхөн сэргээлтийн талбайд үрээр тариалахад гар аргаар эсвэл техник ашиглан тарьж болно. Гараар тарьж байгаа тохиолдолд таримлын үрийг аль болох жигдтараан цацаж, үрлэсний дараа булдаж өгвөл зохистой. Техникээр тарьж байгаа тохиолдолд үр суулгах гүний хэмжээг 3 см-ээс хэтрүүлэхгүй, тариалалтын мөрийг орон нутгийн зонхилох салхины хөндлөн чиглэлд сонгоно. Ургамлыг тариалсны дараа өсөлт, ургалтыг нь байнга ажиглан, шаардлагатай гэж үзвэл зарим агротехникийн ажилбаруудыг хийнэ. Үүний тулд тарьсан ургамлыг бие даан ургах чадвартай болтол нь усална.

Нөхөн сэргээлтийн ажлыг үр дүнтэй болгохын тулд хөрс сайжруулах арга хэмжээг авах хэрэгтэй. Хөрс сайжруулах аргыг ашигласнаар ургамлын амьдралтын хувь өсөж цаашид байгалийн аясаараа өөрөө нөхөн сэргэх боломжийг бүрдүүлж өгдөг сайн талтай. Тиймээс хөрс сайжруулах агротехникийн арга хэмжээг доорхи хүснэгтээр харуулав.

Хүснэгт 8. Агротехникийн үндсэн элементэд тавих шаардлага

Хөрсийг булах	Тарихын өмнө хойно
Тарихын өмнө үрийг дэвтээх	Усалгаатай нөхцөлд стандартад зааснаар
Хөрсний үржил шимийг баяжуулах	Бууц 10 – 20 тн/га Биоялзмаг 10 – 20 кг/га
Өвслөг ургамлыг тарих хугацаа	Зуны эхэн сард бороо угтуулан тарих
Мөрлөж тарихад салхины чигийг тооцох	Зонхилох салхины хөндлөн чигт
Нөмрөг ургамал сонгох	Усалгаатай бол таримал ургамлыг, усалгаагүй бол ганд тэсвэртэй ургамлыг сонгож үндсэн ургамал дээр нэмж 1.0 га-д 0,8 – 1,5 сая ширхэгээр үрлэнэ.
Усалгааны норм	200 – 400 тн
Усалгааны давтамж	5 – аас цөөнгүй

Үрийн нормыг нэгж га-д сая ширхэгээр илэрхийлснийг хөдөө аж ахуйн тарималын үрийн нормыг жинд шилжүүлдэг аргаар 1000 ширхэг үрийн жинд үндэслэн тооцно.

Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн технологийн үндсэн элемент ба шаардлага

№	Хийх ажил	Хэмжих нжгж	Хэрхэн гүйцэтгэх	Тавих шаардлага
1	Бууц, үргэс, биоялмагийг шимт хөрсийг баяжуулахад зориулж тээвэрлэх	тн/км	Авто-машин бусад техник	Тээвэрлэлтийн үеийн шимт хөрсний чийгшил, салхины хүчийг тооцох
2	Агуулахаас ачих хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх бичил амьдралыг идэвхжүүлэх	тн	Техник болон гараар	Агротехнологийн карт
3	Шимт чанарыг нь нэмэгдүүлэн идэвхижүүлсэн шимт хөрсийг ачих, нөхөн сэргээлтийн талбайд буулгах, тараан байршуулах	тн/га тн	Техник болон гараар	Ачих буулгах ажлын норм норматив, үнэлгээ, сиандарт Тээвэрлэлтийн үед шимт хөрсний чийгшил салхины хүчийг тооцох
4	Нөхөн сэргээлтэнд бэлтгэгдсэн шимт хөрсний нягтшилыг тохируулах, булдах	га	ХАА-н техникээр	Хөрсийг эдлэншүүлэх ХАА-н норм норматив, үнэлгээ, стандарт
5	Нөхөн сэргээлтэд тарих үрийн орц нормыг тооцох, үрийг бэлтгэх, тээвэрлэх, нарлуулах,	тн кг	Техник болон гараар	Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий

“БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	чийглэх			шаардлага. MNS 5918:2008
6	Нөхөн сэргээлт хийхээр бэлтгэсэн талбайд ургамлыг тарих, үрлэх	га	ХАА-н техникээр	ХАА-н үрэлгээний норм, норматив, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах” MNS5918:2008
7	Нөхөн сэргээлтээр үрэлгээ хийсэн талбайг услах	Удаа, га,тн\га	Гадаргуугаар болон бороожуулагчаар	Усалгааны норм, норматив
8	Нөхөн сэргэж байгаа ургамлан нөмрөгт ажиглалт, хяналт хийх	Хүн\өдөр	Ажиглалтаар	Хянан баталгаа
9	Мод тарих нүх ухах, бууц ялзмаг бэлтгэх, нүхний хажууд байршуулах	Нүх\хүн	Техник болон гараар	Мод тарих суулгах ажлын норм норматив, стандартууд
10	Мод сонгох, тоо ширхэгийг тооцоолох, тээвэрлэх, ачиж буулгах, тарьж суулгах	Хүн\өдөр	Техникээр болон гараар	
11	Мод суулгах, услах	Хүн\мод	Техникээр болон гараар	
12	Давтан үрэлгээний үрийн орц нормыг тооцох, бэлтгэх тээвэрлэх	тн/га тн,кг тн\км	Техникээр болон гараар	Стандарт норм, норматив
13	Давтан үрэлгээ болон давтан усалгаа хийх	га	Техникээр болон гараар	Агротехнологийн карт

4.5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Нөхөн сэргээлтийн ажлын зардлын тооцоог Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 03-р сарын 30-ны өдрийн А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-аар тооцов.

Техникийн нөхөн сэргээлтийн ажлын үе шатанд уурхайлалтанд өртөж чөлөөлөгдсөн орон зайг цаашид аж ахуйн үйл ажиллагаанд үргэлжлүүлэн ашиглах зорилгоор бэлтгэх арга хэмжээнүүд орно. Үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 17.8га талбайд техникийн болон биологийн сэргээлт хийнэ. Нийт техникийн нөхөн сэргээлтийн уулын 446.58 м³ ажил байна.

Эвдэгдсэн талбайг хэлбэржүүлэх ажлын зардал

Хэлбэржүүлэх ажлын хэмжээ нь нийт хоосон орон зай буюу газар шорооны ажлын 30%-иар тооцоно.

Хүснэгт 10. Бульдозероор хэлбэржүүлэх ажлын зардал (7 дахь жил)

Зардлын нэр	Томъёо	Бодолт
Тэгшлэх ажлын хэмжээ, м ³	$V_{пл}$	133974.0
Чулуулгийг түрэх үеийн бульдозерийн бүтээл, м ³ /цаг	$Q_{ц} = \frac{3600 * V * a * K_{ца} * K_n}{T * K_c}$	651.5
Нийт ажиллах хугацаа, цаг	$T = \frac{S_{нний}}{S * K_{эжк}}$	174.8
Түлш, ШТМ-ын зардал, мян.төг	$C_{от} = T * TЗ_{ц} * 1.15 * P_{от}$	16282.0
Сэлбэг, мян.төг	$C_{сз} = X O_{бульд} * k * t / T_k$	1529.4
Цалингийн зардал, мян.төг	$C_{ц} = T * Ц_{ц}$	874.0
Нийгмийн даатгалын шимтгэл, мян.төг	$C_{нош} = C_{ц} * 0.13$	113.6
Элэгдэл, хорогдлын зардал, мян.төг		7647.2

“БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	$C_{эхи} = XO_{тех} * H_э * t / T_k$	
Нийт зардал	26446.2 мян.төг	
1.0 м ³ болон 1.0м ² чулуулгийг хэвгийжүүлэх ажлын өөрийн өртөг	$a = C_{нийт} / V$	0.2

Нөхөн сэргээлт хийгдэх талбайг тэгшлэх ажлын зардал

Уурхайн дүүргэлт хийсэн талбай болон хэлбэржүүлэлт хийсэн нийт талбайг тэгшилнэ. Нийт тэгшлэлт хийх талбай нь $178000 \text{ м}^2 * 0,2 \text{ м} * 1,05 = 37380.0 \text{ м}^3$ хэмжээтэй газар шорооны ажил хийгдэнэ.

Хүснэгт 11. Бульдозероор тэгшлэх ажлын зардал (7 дахь жил)

Зардлын нэр	Томъёо	Бодолт
Тэгшлэх ажлын хэмжээ, м ³	$V_T = S_{нийт} * h * k_c$	37380.0
Талбайг тэгшлэх үеийн бульдозерийн бүтээл, м ² /цаг	$Q_{ц} = 3600 * L * (1 * \sin \gamma - b) * K_{ц} * n * (\frac{1}{v} + t_э)$	$Q_{ц} = 3600 * 250 * (1.17 \sin 30 - 0.4) * 0.85 * 2 * (\frac{250}{100} + 60) = 1132.2 \text{ м}^2 / \text{цаг}$
Нийт ажиллах хугацаа, цаг	$T = V_T / Q_{ц} * K_{ay}$	29.7
Түлш, ШТМ-ын зардал, мян.төг	$C_{ом} = T * T_{з_ц} * 1.15 * P_{ом}$	2767.8
Сэлбэг, мян.төг	$C_{сэ} = XO_{бульд} * k * t / T_k$	260.0
Цалингийн зардал, мян.төг	$C_{ц} = T * Ц_{ц}$	148.6
Нийгмийн даатгалын шимтгэл, мян.төг	$C_{нош} = C_{ц} * 0.13$	19.3
Элэгдэл, хорогдлын зардал, мян.төг	$C_{эхи} = XO_{тех} * H_э * t / T_k$	1300.0
Нийт зардал	4495.7 мян.төг	
1.0 м ³ хөрс тэгшлэх ажлын өөрийн өртөг	$a = C_{нийт} / V$	Эзэлхүүнээр: $a = 0,1 \text{ мян.төг/м}^3$ Талбайгаар: $A = 174,5 \text{ мян.төг/га}$

Тэгшилсэн талбайг шимт хөрсөөр хучих ажлын зардал

Техникийн нөхөн сэргээлт хийсэн 17.8га талбайг , шимт хөрсөөр хучихад 9345.0 м^3 шимт хөрс хэрэгтэй болно.

Хүснэгт 12. Шимт хөрсөөр хучих ажлын зардал (7дахь жил)

Зардлын нэр	Томъёо	Бодолт
Хучих ажлын хэмжээ, м ³	$V_T = S_{нийт} * h * k_c$	9345.0
Утгуурт ачигчийн цагийн бүтээл, м ³ /цаг	$Q_{уАц} = \frac{3600 * K_{ца} * E_{ам} * K_{уд} * \gamma}{(t + 3.6 (\frac{L_a}{V_a} + \frac{L_x}{V_x}) + t) * K_c}$	$Q_{уАц} = \frac{3600 * 0.85 * 3 * 1.1 * 1.8}{(45.5 + 3.6 (\frac{100}{11.5} + \frac{100}{16}) + 3) * 1.05} = 159.5$
Нийт ажиллах хугацаа, цаг	$T = V_T / Q_{ayц} * K_{ay}$	49.8
Түлш, ШТМ-ын зардал, мян.төг	$C_{ом} = T * T_{з_ц} * 1.15 * P_{ом}$	1546.3
Сэлбэг, мян.төг	$C_{сэ} = XO_{бульд} * k * t / T_k$	280.1
Цалингийн зардал: мян.төг	$C_{ц} = T * Ц_{ц}$	249.0
Нийгмийн даатгалын шимтгэл, мян.төг	$C_{нош} = C_{ц} * 0.13$	32.4
Элэгдэл, хорогдлын зардал, мян.төг	$C_{эхи} = XO_{тех} * H_э * t / T_k$	1400.7
Нийт зардал	3508.5 мян.төг	
1.0 м ³ шимт хөрс ачиж тээвэрлэх ажлын өртөг	$a = C_{нийт} / V$	$a = 0,4 \text{ мян.төг/м}^3$

“БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, НӨХӨН
СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нягтаршуулах ажлын зардал

Биологийн нөхөн сэргээлтэнд бэлтгэн нөхөн сэргээх талбайг скреперээр нягтаршуулна.
Нягтаршуулах ажлын хэмжээ нь $178000.0\text{м}^2 * 0,1\text{м} * 1,05 = 9345.0\text{м}^3$ хэмжээтэй болно.

Хүснэгт 13. Скреперийн ажлын зардал (7 дахь жил)

Зардлын нэр	Томьёо	Бодолт
Тэгшлэх нягтруулах ажлын хэмжээ, м3	$V_T = S_{\text{нийт}} * h * k_c$	9345.0
Талбайг тэгшлэх үеийн дугуйт скреперийн бүтээл, м3 /цаг	$Q_{\text{скр}} = \frac{K_c * V_{\text{скр}}}{T_{\text{ц}} * K_{\text{уд}}}$	$Q_{\text{скр}} = \frac{1,6 * 4,5 * 3600}{T_{\text{ц}} 178,9 * 0,6} = 241,54$ $T_{\text{ц}} = 20 + 93,9 + 15 + 50 = 178,9\text{сек}$
Нийт ажиллах хугацаа, цаг	$T = V_T / Q_{\text{скр}} * K_{\text{ау}}$	32.9
Түлш, ШТМ-ын зардал, мян.төг	$C_{\text{ом}} = T * T_{\text{ц}} * 1.15 * P_{\text{ом}}$	1702.1
Сэлбэг, мян.төг	$C_{\text{сэ}} = XO_{\text{бульд}} * k * t / T_k$	143.9
Цалингийн зардал, мян.төг	$C_{\text{ц}} = T * Ц_{\text{ц}}$	164.5
Нийгмийн даатгалын шимтгэл, мян.төг	$C_{\text{нши}} = C_{\text{ц}} * 0.13$	21.4
Элэгдэл, хорогдлын зардал, мян.төг	$C_{\text{эхи}} = XO_{\text{тех}} * H_{\text{э}} * t / T_k$	719.5
Нийт зардал	2751.4 мян.төг	
1.0 м3хөрсийг тэгшлэх, талбайг хөрсжүүлэх ажлын өөрийн өртөг	$a = S_{\text{нийт}} / V$	а Эзэлхүүнээр: 0,2 мян.төг/м3 а Талбайгаар: 111,4 мян.төг/га

Техникийн нөхөн сэргээлтийн ажлын нийт зардал

$Z_{\text{НС}} = C_{\text{хэль}} + C_{\text{тэгш}} + C_{\text{хуч}} + C_{\text{нягт}} = 26446.2 + 4495.7 + 3508.5 + 2751.4 = 37\,201\,778$ төгрөг болж байна.

**“БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, НӨХӨН
СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

4.6. Биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардал

Биологийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд 1 наст ургамлын үрийг тарьж ургамалжуулах ажил хийгдэнэ.

Биологийн нөхөн сэргээлтэнд техникийн нөхөн сэргээлт хийсэн 17.8га талбайд биологийн нөхөн сэргээлт хийнэ.

Хүснэгт 14. Биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардал

Нэг наст ургамлыг тарих ажлын зардал			
	Нэгж	Нийт	Нийлбэр зардал, мян.төг
Нөхөн сэргээлт хийх талбай, га	100%	17.8	12403.00
1 га-д шаардлагатай үрийн норм, кг	4.5	4,5*17.8=80.10	
1кг үрийн зах зээлийн үнэ, мян.төг	30.0	80.10*30.0=2403.00	
Цалин, мян.төг	50.0	50,0*10хоног*10хүн=5000	
Техникийн зардал	5000.0		
Олон наст ургамлыг тарих ажлын зардал			
Нөхөн сэргээлт хийх талбай, га	100%	17.8	19078.00
1 га-д шаардлагатай үрийн норм, кг	25.5	25.5*17.8=453.90	
1кг үрийн зах зээлийн үнэ, мян.төг	30.0	453.90*30.0=9078.00	
Цалин, мян.төг	50.0	50,0*10хоног*10хүн=5000	
Техникийн зардал	5000.0		
1кг бордооны үнэ, мян.төг	2.3	8900.0*2.3=20470.0	

Биологийн нөхөн сэргээлтэнд шаардлагатай нийт зардал **51 951 000 төгрөг** болж байна.

ТАВ. УУРХАЙН ХААЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ДАРААХ МОНИТОРИНГ

Уурхайн хаалтын дараах мониторингийн арга хэмжээ нь тодорхой давтамжтайгаар байгаль орчинд (агаар, хөрс, ус, ургамал, амьтан) гарах өөрчлөлтийг хянаж шаардлагатай арга хэмжээг тодорхой хугацаанд (3-5 жил зарим тохиолдолд түүнээс олон жил) хэрэгжүүлдэг.

Биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүн, байгалийн нөхөн сэргээгдэх байдал нь удаан хугацааны турш үргэлжилдэг процесс учраас орон нутаг тухайн газрыг хүлээн авснаас хойш ургамжилт нөхөн сэргээлтийн явц байдлыг хянах хэрэгтэй болдог. Тиймээс энэ ажилд шаардлагатай зардлыг төлөвлөн орон нутгийн төсөвт шилжүүлэн өгөх шаардлагатай.

5.1. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ДАРААХ МОНИТОРИНГ

Хаалтын нөхөн сэргээлтийг үр дүнтэй болгох үндэс нь мониторинг хийх явдал юм. Нөхөн сэргээлтийн ажил нь тухайн жилийн байгаль, цаг уурын онцлогоос хамаарч, янз бүрийн үр дүнтэй байж болох тул ялангуяа эхний жилийн нөхөн сэргээлтийн үр дүнг хянан магадлах зайлшгүй шаардлагатай. Хянан магадлагаагаар тогтоосон нөхөн сэргээлийн үр дүн дараа жилдээ ургамлан нөмрөгийн бүрхцийн хэмжээгээр нийт талбайн 30 хувьд хүрэхгүй бол олон настyg бүрхэвч ургамлын дор тарих ажлыг өмнөх жилийн үрийн нормоос 20-25 хувиар бууруулан дахин тариалах шаардлагатай. Нөхөн сэргээлтийн үндсэн таримлыг дахин тариалсан тохиолдолд агротехникийн үндсэн шаардлагыг өмнөхийн адил дагаж мөрдөнө.

Биологийн нөхөн сэргээлтийн үндсэн шаардлага нь нөхөн сэргээлтийг хийж байгаа тухайн нутгийн ургамлан нөмрөгийн үндсэн хэв шинжид ойртуулах явдал юм. Үүний тулд нөхөн сэргээлтэд сонгож байгаа ургамлын төрөл зүйл нь тухайн нутгийн 50 хүртэлх км-ийн радиус доторхи ургамлан нөмрөгийн төлөвшилтэй дүйцэж байх шаардлагатай. Нөхөн сэргээлт хийж буй талбайн ойролцоох гортигт эвдрээгүй орон зайд 50 км-ийн дотор ой, төгөл, шугуй байгаа бол нөхөн сэргээлтэд мод, сөөг, сөөглөг ургамлыг сонгон тарьж болно. Төсөлд тусгагдсан уул-техникийн нөхөн сэргээлтийн бүх ажлыг хийж дууссаны дараа ургамлан нөмрөгийг сэргээхийн тулд шимт хөрсийг байршуулснаар биологийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг эхэлсэн гэж үзнэ.

Нөхөн сэргээлтийн үр дүнд тавих үндсэн шаардлага:


- ❖ Нөхөн сэргээсэн талбайн сэргэсэн ургамлан нөмрөгийн бүрхэц ойролцоох нутгийн ургамлан нөмрөгийн 60 хувьд хүрсэн байх;
- ❖ Нөхөн сэргээсэн талбайн ургамлан нөмрөгийн зүйлийн бүрэлдэхүүн ойролцоох эвдрээгүй талбайн зүйлийн бүрэлдэхүүний 30 хувьд;
- ❖ Нөхөн сэргээсэн талбайн ургамлан нөмрөгийн бүрхцэд хүмүүнсэг ургамлын эзлэх хэмжээ хээрийн болон говийн бүсэд 25 хүртэл хувьд хүрсэн байвал нөхөн сэргээсэн талбайг байгалийн аясаар ургуулахаар үлдээнэ.

Нөхөн сэргээлтийн дараах хөрсний хяналт. Хөрсний хяналтыг хийхдээ хаягдсын сангийн үндсэн талбай хаалтын далангийн ёроол болон ойролцоох эрүүл газарт тус тус мониторингийн цэгийг сонгоно. Хяналт, ажиглалт хэмжилт хийх хугацааг хавар 5 дугаар сар, намар 9 дүгээр саруудад хийх ба жилд 2 удаагийн давтамжтайгаар гүйцэтгэнэ. Хөрсний

“БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, НӨХӨН
СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

хяналтыг тогтоохдоо хаягдлын сан болон эрүүл газрын хөрсний физик-химийн шинж чанар дээр үндэслэнэ.

Хөрсний үржил шимийн бууралт нь физик-химийн шинжийг доройтуулж, биологийн идэвхийг сулруулдаг. Мөн хөрсний чийгийн хангамж, ус барих чадвар, нягтшил, эзэлхүүн жин, механик бүрэлдэхүүний төлөв, сүвэрхэг шинж зэрэг нь тухайн хөрсний нөхөн сэргээгдэх чанарыг илтгэх бөгөөд ийм төрлийн ажлыг дээр сонгосон хяналтын цэгүүдэд хийж байх шаардлагатай. Хэрэв нөхөн сэргээлт хийгдсэн газрын хөрсний үржил шим тогтвортой буурч, доройтож байвал нэмэлт хөрөнгө гарган нөхөн сэргээлтийн ажлыг дахин гүйцэтгэх хэрэгтэй.



Мониторингийн зардлын хэмжээг тооцохдоо нийт нөхөн сэргээлтийн зардлын дүнгийн 10%-иар тооцлоо.

$Z_M = Z_{HC} * K_M * K_{OH} = 89\,152\,778 * 0,1 * 0,9 = 8\,023\,750$ төгрөг мониторингийн зардалд төсөвлөн орон нутгийн төсөвт шилжүүлэх хэрэгтэй.

“БАЯНГОЛЫН ДЭНЖ”-ИЙН АЛТНЫ ШОРООН ОРДЫН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, НӨХӨН
СЭРГЭЭЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**ЗУРГАА. УУРХАЙН ХААЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН НЭГТГЭЛ**

Төв аймгийн заамар сумын нутагт орших Баян овоот уулын дэнжийн хэсгийн алтны шороон ордын ашиглалтын дараа гүйцэтгэх Хаалтын төлөвлөгөөний нийт зардал нь **97 176 528** төгрөг байна.

№	Гүйцэтгэх ажил	Зардал
1	Ашиглагдах тоног төхөөрөмж	Түрээсийн зардал
2	Төслийн талбайг цэвэрлэх, барилга байгууламжуудыг буулгах	Үйл ажиллагааны зардал
3	Техникийн нөхөн сэргээлтийн ажил	37 201 778
4	Биологийн нөхөн сэргээлтийн ажил	51 951 000
5	Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн дараах мониторинг	8 023 750